

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АВТО ЗАМЫН САНГИЙН
ЗАХИРАЛ Р.БУД ТАНАА

2020.03.13 № 06/862
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Авто замын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Авто замын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Авто замын сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих, нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Авто замын сангийн захирал Р.Буд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой хуульд заасан бусад эх үүсвэрээс /зам ашигласны төлбөрөөс бусад/ орлого төвлөрүүлэх, төлбөрийн баримт олгож хэвших, цалинтай адилтгах орлогоос шимтгэл, татвар тооцох, цэгүүдийн автомат хаалтыг бараа материалд бүртгэх, үнэт цаасны тайланг тайлант хугацаагаар тасалбар болгон бэлтгэж, тайлагнах, төсвийг үйл ажиллагааны зардалд үндэслэн бодитоор батлуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Авто замын сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 05-аас 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Санхүүч-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Санхүүч-Аудит” ХХК-д 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 01/60 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Авто замын сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго авто зам, тээврийн талаар гарсан хууль тогтоомж, зам тээврийн хөгжлийн яам болон Төрийн өмчийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны чиглэлээр дэмжлэг үзүүлэхэд оршино.

Авто замын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Олон улс, улсын болон нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засвар, түүнтэй холбоотой үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалт бүхий “Авто замын сан”-тай байна.
- Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.
- Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 282 дугаар “Хурдны авто зам ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоол.
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 274 дугаар “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам” батлах тушаал.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Авто замын сангийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Авто замын сан нь нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Авто замын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Авто замын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,193,911.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 11,939.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 21,499.6 мянган төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан зардлын төсвийг суурь болгон авч үзсэнтэй тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Авто замын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 209,540.1 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	250,152.5	252,880.9	2,728.5
Авлага	212.2	-	(212.2)
Бараа материал	3,479.5	14,146.4	10,666.9
Үндсэн хөрөнгө	1,872,387.5	1,649,664.2	(222,723.3)
Нийт хөрөнгө	2,126,231.6	1,916,691.5	(209,540.1)
Өр төлбөр	208.6	-	(208.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,126,023.	1,916,691.5	(209,331.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,126,231.6	1,916,691.5	(209,540.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 252,880.9 мянган төгрөг нь арилжааны дараах банкуудад байршиж байна. Үүний 250,150.2 мянган төгрөг нь Хаан банкны 5013170948, 2,730.7 мянган төгрөг нь Голомт банкны 1705150884 тоот харилцах дансад тус тус байршиж байна. Голомт банк дахь 2,730.7 мянган төгрөг нь зам ашигласны төлбөрийн орлого, Хаан банк дахь 250,150.2 мянган төгрөг нь “Би Би сервис” ХХК-д өгөх Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвийн хэсэгчилсэн хатуу хучилттай 2.5 км авто замын ажлын үлдэгдэл төлбөр байна. “Би Би сервис” ХХК нь тооцоологдоогүй тээврийн зардалд гарсантай холбоотой гэрээний дүнгээр замын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тул гэрээг сунгах, нэмэлт санхүүжилтийн асуудлыг тавьсан ба шийдвэрлэгдээгүй байна.

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын банкны бүх дансыг татварын байгууллагаас хаасантай холбоотой Голомт банк дахь үлдэгдлийг төвлөрүүлж чадаагүй байна.

Бараа материалын үлдэгдэлд 1,617.6 мянган төгрөгийн үнэт цаас, 464.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 126.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 11,938.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материалууд байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн элэгдэл байгуулснаас шууд шалтгаалжээ. Тайлант онд ТӨБЗГ-ын 2019 оны 307 дугаар тогтоолоор Увс аймгийн орон нутгийн өмчийн газраас 25,000.0 төгрөгийн байгууламж /Чандмань төлбөр авах цэгийн байр/ шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2019 оны 319 дүгээр тогтоолоор 101,009.3 мянган төгрөгийн байгууламж /Дархан болон Улаангомын төлбөр авах цэгийн байр/, ашиглах боломжгүй 2,315.5 мянган төгрөгийн программ хангамжийг тус тус данс бүртгэлээс хассан байна. Тайлант хугацаанд байгуулсан элэгдэл, хорогдлын зардал 197,492.2 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,916,691.5 мянган төгрөг болж 209,540.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ. Тайлант оны үйл ажиллагааны үр дүн алдагдалтай гарахад үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал болон данс бүртгэлээс хассан барилга байгууламжийн гарз нөлөөлсөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Авто замын сан нь тайлант онд 6,500,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 8,866,366.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 136.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөгөөр/				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Зам ашигласны төлбөр	6,500,000.0	8,866,366.8	2,366,366.8	136.4

Авто замын сангийн төсөвт төвлөрүүлэх орлого 6,500,000.0 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 8,866,366.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Төлөвлөгөө 2,366,366.8 мянган төгрөгөөр давсан нь авто машины хөдөлгөөний эрчим нэмэгдсэн, хурдны замын төлбөр авах цэг шинээр ашиглалтад орсноос шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн захирагчийн урсгал зардалд 2,149,962.0 мянган төгрөгийг зарцуулах, эх үүсвэрийг өөрийн орлогоос бүрдүүлэхээр батлагджээ.

Зам ашигласны төлбөрийн 8,866,366.8 мянган төгрөгийн орлогоос:

- 2,149,962.0 мянган төгрөгийг батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааны зардалд,
- 2,690,600.0 мянган төгрөгийг зам засварын ажилд,
- 3,847,614.1 мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлгээр,
- 175,460.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр үйл ажиллагааны зардалд зарцуулж 2,728.5 мянган төгрөг нь Голомт банкны харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын 2019 оны 266 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 он 185 дугаар тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 236 тоот тушаалаар Үерийн улмаас

эвдэрсэн улсын чанартай авто зам, замын байгууламж, зарцуулах хөрөнгийн санхүүжилт 1,405,600.0 мянган төгрөг, Мөн Сангийн сайдын 2019 оны 251 тушаал болон Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 320 тоот Засварын ажил гүйцэтгэх, замын жагсаалт, зарцуулах хөрөнгө батлах тухай тушаалаар 1,285,000.0 мянган төгрөг, нийт 2,690,600 мянган төгрөгийг авто замын сангаас санхүүжүүлсэн.

Давсан орлогоос 175,462.2 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгож, улсын төсөвт 3,847,614.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,149,962.0 мянган төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Байгууллагын 2019 оны төсвийг батлахдаа өмнөх оны зардлыг нэмж батлаагүйгээс төлбөр авах цэгүүдийн хураагч нарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжих хэмжээг 2019 онд 320.0 мянган төгрөгөөр тогтоосон тул цалин, шимтгэлийн зардлын төсөв хүрэлцээгүй болсон байна. Үүнтэй холбоотой Сангийн яамны төрийн сангийн газарт хүргүүлсэн Зам тээврийн хөгжлийн яамны 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Санхүүжилт шийдвэрлүүлэх тухай 03/5981 албан тоотын дагуу 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 175,462.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 64.5 хувийг цалин, шимтгэлийн зардалд, 35.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид зарцуулжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүлээ.

Аудитаар нийт 5,607.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 459.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 5,148.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан болон нэмэлт санхүүжилтийн тайланг бэлтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ...” гээд 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад тайланг бэлтгүүлэв.

2. Хаан банк дахь харилцах дансны хуулгыг цахим хуудсаас хэвлэсэн, интернет банкаар шилжүүлсэн гүйлгээний баримтуудыг тамга, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавартай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

3. Бараа материалын дансанд 459.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1 дэхь заалт, УСНББОУС-12 Бараа материал стандартын 9 дүгээр заалттай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

Аудитаар илэрсэн 5,148.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Авто замын тухай хуульд “улсын авто замын сангийн хөрөнгийн эх үүсвэрийг импортоор оруулж байгаа автомашины онцгой албан татварын 20-иос доошгүй хувь, гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгө, улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр, олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс авах төлбөр, хураамж, авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр, бусад төлбөрөөс бүрдэнэ” гэж заасан боловч зөвхөн авто зам ашигласны төлбөрөөр эх үүсвэр бүрдүүлж байна.

Засгийн газрын 2019 оны 266 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 он 185 дугаар тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 236 тоот тушаалаар Үерийн улмаас эвдэрсэн улсын чанартай авто зам, замын байгууламж, зарцуулах хөрөнгийн санхүүжилт 1,405,600.0 мянган төгрөг, Мөн Сангийн сайдын 2019 оны 251 тушаал болон Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 320 тоот Засварын ажил гүйцэтгэх, замын жагсаалт, зарцуулах хөрөнгө батлах тухай тушаалаар 1,285,000.0 мянган төгрөг, нийт 2,690,600 мянган төгрөгийг авто замын сангаас санхүүжүүлсэн.

Эдгээр асуудлуудыг дараах аудитаар авч үзэх шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Авто замын сан нь бие даасан хуулийн этгээдийн статусгүй “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын нэгж тул Шилэн дансны цахим хуудсанд нэвтрэх эрх олгогдоогүй ба “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын цахим хуудсанд “Шилэн данс” гэсэн тусгай цэс нээж мэдээллийг оруулдаг байна. Мэдээллүүдийг төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, үнэт цаас, байгууллага гэсэн төрлүүдээр оруулжээ.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлснээс зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 5,148.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 21,499.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

“Зөрчилгүй” дүгнэлт

Авто замын сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Ажилтанд олгосон 800.0 мянган төгрөгийн шагналаас татвар суутган тооцоогүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна” гээд “7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Татварын алданги, торгууль үүсэх, татварын тооцоололд алдаа гарах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цалин, түүнтэй адилтгах орлогуудаас шимтгэл, татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцох.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Татварыг нөхөн тооцож, цаашид анхаарч ажиллана.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Үнэт цаасыг Төлбөр авах цэгүүдэд олгохдоо шууд зардалд тусгадаг, төлбөр авах цэгүүдийн ахлагч нар үнэт цаасны тайлангаа сар бүрийн 20-ны өдөр тасалбар болгон гаргадаг ба 2019 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгон уг тайланг бэлтгүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Байгууллагын зардал буруу илэрхийлэгдэх хөрөнгө дутагдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын зарлагыг төлбөр авах цэгүүдийн үнэт цаасны тайлангаарх зарлагын дүнгээр бүртгэлээс хасах, тайлант үе бүрээр тасалбар болгон тайланг бэлтгэж хэвших.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 *Балансын данстай холбоотой асуудал*

3.3.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд худалдан авсан нийт 49,780.0 мянган төгрөгийн 19 ширхэг төлбөр авах цэгийн автомат хаалтыг багаж хэрэгслийн зардалд бүртгэсэн нь УСНББОУС-12 Бараа материалын 9-д “Бараа материалд дараах хөрөнгүүд орно... үйлдвэрлэлийн явцад ашиглагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Байгууллагын зардал буруу илэрхийлэгдэх, хөрөнгө дутагдах.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Замын автомат хаалтуудыг бараа материалд бүртгэж, ашиглалтаас гарсан үед нь зардлаар тусгах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Автомат хаалтууд нь 6-12 сарын хугацаанд ашиглалтаас гардаг тул шууд зардалд бүртгэсэн. Цаашид бараа материалаар бүртгэж, ашиглалтаас гарах үед нь зарлагдаж байх болно.

3.4 *Зардлын данстай холбоотой асуудал*

3.4.1 Илрүүлэлт:

Тус сан нь бие даасан хуулийн этгээдийн статусгүй тул төлбөрийн баримт /ебаримт/-ийн хувьд “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын регистрийн дугаараар шивэгддэг зарцуулалт 2 байгууллага дээр давхар илэрхийлэгдэх эрсдэлтэй нь Татварын ерөнхий хуулийн 29.1-д “29.1.1.анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх” гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн зам ашигласны төлбөрт төлбөрийн баримт олгохгүй байгаа нь мөн хуулийн 28.5-т “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Байгууллагын зардал төлбөрийн баримтаар нотлогдохгүй байх, төлбөр тооцоо ойлгомжгүй байдал үүсэх. Зам ашигласны төлбөр дутуу төвлөрөх.

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Татварын тайланг “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-аас тусдаа бэлтгэж, төлбөрийн баримтыг уг байгууллагаас өөр регистрийн дугаараар авах. Зам ашигласны төлбөрт үнэт цаасны оронд төлбөрийн баримт өгч хэвших. Эдгээр асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг анхаарч ажиллана.

3.5 Төсөв, төсвийн гүйцэтгэл

3.5.1 Илрүүлэлт:

Байгууллагын 2019 оны төсвийг батлахдаа өмнөх оны зардлыг нэмж батлаагүйгээс төлбөр авах цэгүүдийн хураагч нарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжих хэмжээг 2019 онд 320.0 мянган төгрөгөөр тогтоосон тул цалин, шимтгэлийн зардлын төсөв хүрэлцээгүй болсон байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 6.2-д “Энэ хуулийн 5.1.1-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ...” гээд 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Төсөв дутуу батлагдах, санхүүжилт тасрах.

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын төсвийг үйл ажиллагааны зардалд үндэслэн бодитоор батлуулах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг анхаарч ажиллана.

3.6 Төсөв, төсвийн гүйцэтгэл

3.6.1 Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ээр Голомт банкны 1705150884 тоот харилцах данс дахь зам ашигласны төлбөрийн орлогын үлдэгдэл болох 2,730.7 мянган төгрөгийг байгууллагын дансыг татварын байгууллагаас андуурч хаасантай холбоотой төсөвт төвлөрүүлж чадаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл:

Үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлэх

3.6.3 Өгсөн зөвлөмж:

Төсөвт төвлөрүүлэх орлогыг тухай бүрт нь улсын төсвийн дансанд төвлөрүүлж байх.

3.6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Татварын байгууллагаас данс андуурч хаасантай холбоотой тайлант онд төвлөрүүлж чадаагүй ч 2020 оны 1 дүгээр сард төвлөрүүлсэн, зөвлөмжийг анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>253,844,112.18</u>	<u>267,027,324.93</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	250,152,448.93	252,880,943.93
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	250,152,448.93	252,880,943.93
3121	Төгрөг	250,152,448.93	252,880,943.93
31213	Арилжааны банк дахь харилцах	250,152,448.93	252,880,943.93
33	АВЛАГА	212,162.50	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	212,162.50	-
35	БАРАА МАТЕРИАЛ	3,479,500.75	14,146,381.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,582,000.75	1,617,649.99
354	Хангамжийн материал	1,897,500.00	12,528,731.01
35420	Аж ахуйн материал	484,000.00	464,000.01
35430	Сэлбэг хэрэгсэл	126,500.00	126,500.00
35470	Бусад хангамжийн материал	1,287,000.00	11,938,231.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,872,387,484.70</u>	<u>1,649,664,206.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,872,387,484.70	1,649,664,206.17
392	Биет хөрөнгө	1,872,387,484.70	1,649,664,206.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,938,551,278.05	1,862,541,998.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	(325,215,701.29)	(393,687,908.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,220,757.80	222,220,757.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(222,220,757.80)	(222,220,757.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	364,075,300.00	364,075,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,058,783.25)	(200,972,399.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,205,550.00	31,205,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,170,158.81)	(13,498,333.81)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	3,135,500.00	820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,135,500.00)	(820,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,126,231,596.88</u>	<u>1,916,691,531.10</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>208,552.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	208,552.00	-
413	Өглөг	208,552.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	191,783.00	-
4136	Бусад өглөг	16,769.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	16,769.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,126,023,044.88</u>	<u>1,916,691,531.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,126,023,044.88	1,916,691,531.10
512	Хуримтлагдсан үр дүн	2,126,023,044.88	1,916,691,531.10
51210	Өмнөх үеийн үр дүн	2,126,023,044.88	2,126,023,044.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	(209,331,513.78)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,126,231,596.88</u>	<u>1,916,691,531.10</u>

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,743,760,569.85	8,901,366,785.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,743,760,569.85	8,901,366,785.24
120	Нийтлэг татварын бус орлого	7,743,760,569.85	8,901,366,785.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,737,734,943.05	8,891,366,785.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,677,543,900.00	8,866,366,785.24
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	60,191,043.05	25,000,000.00
120009	Бусад орлого	6,025,626.80	10,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,031,556,137.28	9,060,467,188.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,026,442,137.28	9,060,467,188.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,477,767,577.28	5,199,460,457.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,790,864,229.10	1,663,731,635.94
210101	Үндсэн цалин	1,790,864,229.10	1,663,731,635.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,372,162.67	208,919,548.67
210201	Тэтгэврийн даатгал	143,808,510.00	142,955,720.86
210202	Тэтгэмжийн даатгал	18,037,736.67	16,575,126.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,304,052.00	13,321,535.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,565,624.00	3,274,520.14
210205	Эрүүл мэндийн даатгал	35,656,240.00	32,792,645.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,953,550.70	44,873,468.00
210301	Гэрэл, цахилгаан	30,359,765.70	38,170,828.00
210302	Түлш, халаалт	13,593,785.00	6,672,500.00
210303	Цэвэр, бохир ус	-	30,140.00
2104	Хангамж, бараа материалын зардал	93,536,991.00	93,940,994.99
210401	Бичиг хэрэг	5,196,590.00	3,328,159.00
210402	Тээвэр, шатахуун	49,307,753.00	72,122,868.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,990,000.00	5,013,615.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	66,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,042,648.00	5,742,570.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	7,667,782.99
2105	Нормативт зардал	45,909,000.00	4,765,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,909,000.00	4,765,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,951,076.00	120,183,590.22
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,069,220.00	90,812,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	350,000.00
210604	Урсгал засвар	13,881,856.00	29,021,090.22
2107	Томилолт, зочны зардал	18,612,720.00	17,804,300.00
210702	Дотоод албан томилолт	18,612,720.00	17,804,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,085,690,632.43	2,770,121,826.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,062,773,994.18	2,735,726,961.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	78,400.00

Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	934,775.00	470,115.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	1,067,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	985,800.00	1,293,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	20,820,063.25	24,919,350.76
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,877,215.38	275,119,592.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,945,378.00	77,627,424.17
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,931,837.38	197,492,168.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,548,674,560.00	3,861,006,731.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,092,960.00	13,392,641.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж	-	1,083,163.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,092,960.00	12,309,478.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,527,581,600.00	3,847,614,090.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,527,581,600.00	3,847,614,090.74
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,114,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	5,114,000.00	-
221001	Их засвар	5,114,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,287,795,567.43)	(159,100,403.65)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	50,231,110.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	50,231,110.13
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(50,231,110.13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,287,795,567.43)	(209,331,513.78)

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,683,569,526.80	8,866,366,785.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,683,569,526.80	8,866,366,785.24
120	Нийтлэг татварын бус орлого	7,683,569,526.80	8,866,366,785.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,677,543,900.00	8,866,366,785.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,677,543,900.00	8,866,366,785.24
120009	Бусад орлого	6,025,626.80	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	11,931,480,600.87	8,863,638,290.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,931,480,600.87	8,863,638,290.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,403,899,000.87	5,016,024,199.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,403,899,000.87	5,016,024,199.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,403,899,000.87	5,016,024,199.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,527,581,600.00	3,847,614,090.74
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,527,581,600.00	3,847,614,090.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,527,581,600.00	3,847,614,090.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(4,247,911,074.07)	2,728,495.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(4,247,911,074.07)	2,728,495.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,498,063,523.00	250,152,448.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	250,152,448.93	252,880,943.93

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	5,174,589,083.97	5,174,589,083.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	5,174,589,083.97	5,174,589,083.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	1,239,229,528.34	1,239,229,528.34
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	2,126,023,044.88	2,126,023,044.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	2,126,023,044.88	2,126,023,044.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	(209,331,513.78)	(209,331,513.78)
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,916,691,531.10	1,916,691,531.10

4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,149,962,300.00	2,149,961,999.50	300.50	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,149,962,300.00	2,149,961,999.50	300.50	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,131,788,300.00	2,136,569,358.50	(4,781,058.50)	100.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,559,997,700.00	1,569,371,635.94	(9,373,935.94)	100.6
210101	Үндсэн цалин	1,559,997,700.00	1,569,371,635.94	(9,373,935.94)	100.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	187,199,724.00	190,089,548.67	(2,889,824.67)	101.5
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	127,295,812.32	129,260,893.10	(1,965,080.78)	101.5
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	14,975,977.92	15,207,163.89	(231,185.97)	101.5
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,995,195.58	3,041,432.78	(46,237.19)	101.5
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	11,980,782.34	12,165,731.11	(184,948.78)	101.5
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	29,951,955.84	30,414,327.79	(462,371.95)	101.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,000,000.00	44,873,468.00	(873,468.00)	102.0
210301	Гэрэл, цахилгаан	38,000,000.00	38,170,828.00	(170,828.00)	100.4
210302	Түлш, халаалт	6,000,000.00	6,672,500.00	(672,500.00)	111.2
210303	Цэвэр, бохир ус	-	30,140.00	(30,140.00)	-
2104	Хангамж, бараа материалын зардал	78,620,000.00	93,940,994.99	(15,320,994.99)	119.5
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	3,328,159.00	271,841.00	92.4
210402	Тээвэр, шатахуун	55,000,000.00	72,122,868.00	(17,122,868.00)	131.1
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	5,520,000.00	5,013,615.00	506,385.00	90.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	66,000.00	(66,000.00)	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс	5,500,000.00	5,742,570.00	(242,570.00)	104.4
210407	Аж ахуйн материалын зардал	9,000,000.00	7,667,782.99	1,332,217.01	85.2
2105	Нормативт зардал	16,200,000.00	4,765,500.00	11,434,500.00	29.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,200,000.00	4,765,500.00	11,434,500.00	29.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,279,876.00	58,335,010.73	(16,055,134.73)	138.0
210601	Багаж техник хэрэгсэл	34,779,876.00	48,963,920.51	(14,184,044.51)	140.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	350,000.00	(350,000.00)	-
210604	Урсгал засвар	7,500,000.00	9,021,090.22	(1,521,090.22)	120.3
2107	Томилолт, зочны зардал	20,000,000.00	17,804,300.00	2,195,700.00	89.0
210702	Дотоод томилолт	20,000,000.00	17,804,300.00	2,195,700.00	89.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	74,900,000.00	79,761,476.00	(4,861,476.00)	106.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,500,000.00	45,126,961.00	3,373,039.00	93.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	6,500,000.00	(3,000,000.00)	185.7
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	-	78,400.00	(78,400.00)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	470,115.00	(470,115.00)	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00	(66,000.00)	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	1,067,500.00	(1,067,500.00)	-

Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	900,000.00	1,293,500.00	(393,500.00)	143.7
210809	Улсын тэмдэгтийн маягт хэвлэх	22,000,000.00	25,159,000.00	(3,159,000.00)	114.4
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	108,591,000.00	77,627,424.17	30,963,575.83	71.5
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	108,591,000.00	77,627,424.17	30,963,575.83	71.5
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,174,000.00	13,392,641.00	4,781,359.00	73.7
	Бусад урсгал шилжүүлэг	18,174,000.00	13,392,641.00	4,781,359.00	73.7
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,174,000.00	13,392,641.00	4,781,359.00	73.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,149,962,300.00	2,152,690,494.50	(2,728,194.50)	100.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,149,962,300.00	2,152,690,494.50	(2,728,194.50)	100.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,149,962,300.00	2,152,690,494.50	(2,728,194.50)	100.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	250,152,448.93	(250,152,448.93)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	252,880,943.93	(252,880,943.93)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	158.00	159.00		
620001	Удирдах ажилтан	20.00	21.00		
620003	Үйлчлэх ажилтан	138.00	138.00		

4.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,462,200.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	175,462,200.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,462,200.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	94,360,000.00
210101	Үндсэн цалин	94,360,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,830,000.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,804,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,506,400.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	301,280.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,205,120.00
210205	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	3,012,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	62,270,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,272,200.00
12	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	175,462,200.00
14	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон нэмэлт орлого	175,462,200.00
15	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	175,462,200.00
16	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
17	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

5. АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.12.31			САГ-2020/14/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Авто замын сан		/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Үнэт цаасыг замын хураамжийн төлбөрийн орлоготой уялдуулах зарчмаар бус төлбөр авах цэгүүдийн ахлагч нарт олгохдоо шууд зарлагадаж данснаас хасдаг. Ахлагч нараар 2019 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгож үнэт цаасны тайлан гаргуулаагүй.	1,617.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Мөнхтуяа
2	Ажилтанд олгосон 800.0 мянган төгрөгийн шагналаас татвар суутгаж тооцоогүй.	800.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Мөнхтуяа
3	Тус сан нь бие даасан хуулийн этгээдийн статусгүй тул төлбөрийн баримт /ебаримт/-ийн хувьд “Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын регистрийн дугаараар шивэгддэг. Мөн зам ашигласны төлбөрт төлбөрийн баримт олгодоггүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Р.Буд Ц.Мөнхтуяа
4	Тайлант хугацаанд худалдан авсан 49,780.0 мянган төгрөгийн төлбөр авах цэгийн автомат хаалтуудыг багаж хэрэгслийн зардалд бүртгэсэн.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Мөнхтуяа
5	2019 оны төсвийг өмнөх оны дүнгээр баталсан. Төлбөр авах цэгүүдийн хураагч нарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжДаг бөгөөд уг хэмжээг 2019 онд 320.0 мянган төгрөгөөр тогтоосон тул цалин, шимтгэлийн зардлын төсөв хүрэлцээгүй болсон байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Р.Буд Ц.Мөнхтуяа
6	2019 оны 12 дугаар сарын 31-ээр Голомт банкны 1705150884 тоот харилцах данс дахь зам ашигласны төлбөрийн орлогын үлдэгдэл болох 2,730.7 мянган төгрөгийг байгууллагын дансыг татварын байгууллагаас андуурч хаасантай холбоотой төсөвт төвлөрүүлээгүй байна.	2,730.7	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Р.Буд Ц.Мөнхтуяа
Дүн		5,148.3			

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.

[illegible]